

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
2025 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

2025.09.29

Улаанбаатар хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО,
ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр Зам, тээврийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, Засгийн газарт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ. Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Монгол Улсын Засгийн газрын 103 тогтоолын 161 заалт, Засгийн газрын хуралдааны 94 тэмдэглэлийн 183 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 4 заалт буюу нийт 201 тогтоол шийдвэрийн 348 заалтад хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжсэн 272 заалт, хэрэгжээгүй 42 заалт, хугацаа болоогүй 34 заалт байгаа бөгөөд хэрэгжилтийн дундаж 87 хувьтай байна.

/Хавсралт-1/

Нийт		ЗГ-ын тогтоол	ЗГ-ын Хуралдааны тэмдэглэл	Ерөнхий сайдын захирамж
Хяналтад авсан шийдвэрийн тоо	201	103	94	4
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	348	161	183	4
Үнэлгээ	Хэрэгжсэн	272	112	157
	Хэрэгжээгүй	42	24	17
	ХБ	34	25	9
Биелэлтийн дундаж		87%	80%	90%
				75%

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Монгол Улсын Засгийн газрын 103 тогтоолын 161 заалт, Засгийн газрын хуралдааны 94 тэмдэглэлийн 183 заалт, Ерөнхий сайдын 4 захирамжийн 4 заалт буюу нийт 201 тогтоол шийдвэрийн 348 заалтад хяналт-шинжилгээ үнэлгээ хийхэд хэрэгжсэн 272 заалт, хэрэгжээгүй 42 заалт, хугацаа болоогүй 34 заалтын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнахдаа үр дүн тодорхойгүй, утга найруулгын алдаатай, заасан хугацаанаас хоцроох зэрэг алдаа дутагдал гарсаар байна.

**ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭ
/ ЗӨВЛӨМЖ /**

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр Зам, тээврийн сайдад өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд 2025 оны 3 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

4.1. Хяналт-шинжилгээний, үнэлгээний тайланд дурдсан хэрэгжилт хангалтгүй 42 арга хэмжээ тус бүрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх чиглэлээр цаашид

хийж хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн дотор Яамны удирдлагад танилцуулахыг нэгжүүдийн удирдлагуудад;

4.2. Хөрөнгө санхүүжилт шаардагдахгүйгээр шийдвэрлэх боломжтой арга хэмжээний бодит үр дүнг нэмэгдүүлэх талаар, зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4.3. Нийтийн тээвэр, төмөр зам, авто замын бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ